



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН
ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 05 сарын 26 өдөр

Дугаар 6/47

Бор-өндөр сум

Сахилгын шийтгэл ногдуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.1, 123.2, 123.2.2, 123.3, Эрүүл мэндийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.4 28.4.3, Эрүүл мэндийн сайдын 2019 оны “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм батлах тухай” А/406 дугаар тушаалын 4 дугаар зүйлийн 4.14 дэх заалт, Нэгдсэн эмнэлгийн “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 11 дүгээр зүйлийн 11.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Хүний их эмч Баярцэнгэлийн Бат-Эрдэнэ нь ажлын цагийг үр бүтээлгүй өнгөрөөх, хууль тогтоомж, байгууллагын үйл ажиллагаатай холбогдуулан тогтоосон дэг журмыг зөрчих, эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх удирдамжийг мөрдөж ажиллаагүй, эмчилгээ үйлчилгээнд дутагдал гаргасан тул сахилгын шийтгэл ногдуулсугай.

2. Б.Бат-Эрдэнэд сахилгын шийтгэлийг нийт ажилтанд зарлах хэлбэрээр нээлттэй сануулах, 1 жилийн үр дүнгийн урамшууллыг хасаж тооцсугай.

3. Ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргийн дагуу өдөр тутмын үйл ажиллагааг оновчтой зохион байгуулж, холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмыг баримтлан ажиллаж, үүрэгт ажилдаа хариуцлагатай хандахыг Б.Бат-Эрдэнэд үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эмнэлзүйн эрхэлсэн дарга (Ч.Мөнгөнчимэг)-д даалгасугай.

5. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хүний нөөцийн мэргэжилтэн (Б.Халиун)-д даалгасугай.

ДАРГА

А.БАТБААТАР

